

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРООНЫ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэгдүгээр зүйл. Байгууллагын нэр, байршил

1.1. Байгууллагын нэр нь монголоор Монголын Үндэсний Олимпийн Хороо, товчлол нь “МҮОХ” (цаашид энэ дүрмэнд товчлолыг хэрэглэнэ), англиар Mongolian National Olympic Committee байна.

1.2. Байршил: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Олимпийн хороо

1.3. Байгуулагдсан он, сар, өдөр: 1956 оны 02 дугаар сарын 26 -ны өдөр

Хоёрдугаар зүйл. Үйл ажиллагааны үндсэн зарчим

2.1. МҮОХ нь Олон Улсын Олимпийн Хартийг удирдлага болгож, олимпийн хөдөлгөөнийг үндэсний болон олон улсын хэмжээнд хөгжүүлэх зорилго бүхий Төрийн бус байгууллага мөн.

2.2. МҮОХ нь **Олимпийн харти** болон Монгол улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль бусад хууль тогтоомжийг хүндэтгэн сахиж өөрийн дүрмийн хүрээнд төр, засгийн болон Төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж , иргэдтэй хамтран ажиллах бөгөөд **Олимпийн Хартийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцох ёсгүй.**

2.3. МҮОХ нь олимпийн хөдөлгөөнийг Монгол улсын нутаг дэвсгэрт бүрэн төлөөлөх эрхтэй.

2.4. МҮОХ нь олимпийн наадам, Олон улсын олимпийн хорооны /цаашид ОУОХ гэж товчилно/ ивээл дор зохиогдох тив, бүс болон дэлхийн спортын олон төрөлт тэмцээнд Монгол улсыг **төлөөлөх онцгой эрхийг Олимпийн Хартийн дагуу дангаар** эдлэнэ.

2.5. МҮОХ нь Олимпийн Хартийг дагаж мөрдөх, бүрэн бие даасан байдлаа хамгаалахад саад тотгор учруулж болох аливаа хэлбэрийн дарамт шахалтыг няцаана.

2.6. Улс төр, **хууль эрх зүй**, шашин, бизнесийн аливаа дарамтыг эсэргүүцэж, тэдгээрээс бүрэн хараат бус байна.

2.7. Монгол улсад биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд тал бүрийн дэмжлэг үзүүлнэ.

Гуравдугаар зүйл. Зорилго

3.1. Монгол улсад олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх, хамгаалах, сурталчилан дэлгэрүүлэх

3.2. Монгол улсын нутаг дэвсгэрт Олимпийн хартийн хэрэгжилтэнд хяналт тавих

3.3. Үндэсний олимпийн академи, олимпийн музей, олимпийн хөдөлгөөний соёл, боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж олон түмэнд түгээн дэлгэрүүлэх

3.4. Спортын мэргэжилтэн, удирдах ажилтныг бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарах, спортын шинжлэх ухааны ололт амжилтыг нэвтрүүлэх

3.5. Тамирчдын спортын амжилтыг дээшлүүлэх, бүх нийтийн спортыг дэмжин хөгжүүлэх

3.6. Спортод ялгаварлан гадуурхах, хүчирхийлэх хэлбэрийг эсэргүүцэж, биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд саад учруулах аливаа сөрөг нөлөөллийн эсрэг идэвхитэй тэмцэх

3.7. Дэлхийн Допингийн эсрэг агентлагийн дүрмийг хүлээн зөвшөөрч **хэрэгжүүлэх, үүнтэй холбогдуулан МҮОХ-ны допингийн эсрэг бодлого ба дүрэм, мөн гишүүнчлэл, санхүүжилтийн шаардлага болон үр дүнгийн менежментийн журмыг Дэлхийн допингийн эсрэг агентлагийн дүрэмд нийцүүлж боловсруулах, Дэлхийн допингийн эсрэг дүрэмд жагсаасан ҮОХ-дын үүрэг, хариуцлагыг сахин биелүүлэх**

3.8. Спортын ёс зүйн олон улсын хэм хэмжээг сахих

3.9. Үндэсний хэмжээнд энх тайван, спорт ба эмэгтэйчүүдийг дэмжих үйл ажиллагааг явуулах, хүрээлэн буй орчны асуудалд онцгой анхаарал хандуулах

3.10. Спортын байгууллага, холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэх

Дөрөвдүгээр зүйл. МҮОХ-ны эрх, үүрэг

- 4.1. Олимпийн Хартийн хүрээнд олимпийн хөдөлгөөний асуудлаар санал боловсруулах
- 4.2. Олимпийн наадмыг зохион байгуулах хотын тухай саналаа ОУОХ-нд өгөх
- 4.3. Олон Улсын Олимпийн Их хурал, үндэсний олимпийн хороодын Ерөнхий Ассамблейд бэлтгэж оролцох
- 4.4. ОУОХ, түүний хүлээн зөвшөөрсөн байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах, туслалцаа авах
- 4.5. Спортын холбоодын саналыг үндэслэн **Олимпийн наадам болон ОУОХ-ны ивээл дор зохиогдох спортын олон төрөлт тив, бүс, дэлхийн тэмцээнд оролцох өөрийн төлөөлөгчдийг бүрдүүлэх, зохион байгуулах, удирдах, мөн багийн гишүүдийн сахилга батын асуудлыг хариуцах**
- 4.6. ОУОХ-ны урилгыг хүлээн авч Олимпийн наадамд үндэсний багийг оролцуулах, **тухайлбал баг тамирчдаа зохион байгуулж зуны болон өвлийн олимпийн наадамд оролцох үүрэг хүлээх**
- 4.7. Олон улсын спортын болон үндэсний байгууллагуудтай Олимпийн Хартийн хүрээнд хамтран ажиллах
- 4.8. МҮОХ-ны зорилгод нийцүүлэн спортын холбоодыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах
- 4.9. Олимпийн эв санааны нэгдлийн хөтөлбөрт хамрагдах, туслалцаа авах
- 4.10. Спортын маркетингийг хөгжүүлэх, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох, хандивлагчидтай хамтран ажиллах
- 4.11. Олимпийн үзэл санааг дэлгэрүүлэн хөгжүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг удирдан зохион байгуулах
- 4.12. Олимп, тив, бүсийн наадамд оролцох тамирчдын эрүүл мэндийг даатгуулан, тэдний эрх ашгийг хамгаалах
- 4.13. Олимпийн хөдөлгөөнд хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг МҮОХ-ны шагналаар шагнаж урамшуулах, төр, засгийн шагналд дэвшүүлэх
- 4.14. Өөрийн оронд олимп, тив, бүсийн наадмыг зохион байгуулах тухай саналаа ОУОХ, Азийн олимпийн зөвлөл (цаашид АОЗ гэх), бүсийн холбоонд өгөх

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МҮОХ-НЫ ГИШҮҮНЧЛЭЛ

Тавдугаар зүйл. Гишүүн байгууллага

5.1. Доорхи спортын холбоод нь МҮОХ-ны гишүүн байгууллага байх ёстой.

1.Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын Олон улсын холбоодын гишүүн болсон үндэсний бүх холбоод

2.Түүнчлэн МҮОХ нь дараах спортын холбоодыг гишүүн байгууллагаар элсүүлж болно. Үүнд:

2.1.ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн ба Олимпийн наадмын хөтөлбөрт ордоггүй спортын Олон улсын холбооны гишүүн үндэсний холбоод

2.2. МҮОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн бусад спортын байгууллагууд болон МҮОХ-ны орон нутгийн салбар зөвлөлүүд

5.2. Гишүүн холбоо нь дараахь нөхцөлийг заавал хангасан байна:

1. Жил бүр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах
2. МҮОХ-ны гишүүний татвар төлсөн байх
3. Жил бүрийн үйл ажиллагааны тайланг гарган өгөх
4. Тухайн спортын холбоо нь олон улсын холбооны гишүүн байх

5.3. Дүрмийн 5.2-т заасан нөхцөлийг 2 жилийн турш хангаагүй холбоо нь гишүүний эрхээ алдана. Ийм холбоо нь дүрмийн 5.4-т заасан нөхцөлийг хангасны дараа гишүүнчлэлээ сэргээж болно.

5.4. Холбоо нь дүрмийн 5.2-т заасан нөхцөлийг 2 жилийн хугацаанд хангасан тохиолдолд МҮОХ-гоор хүлээн зөвшөөрөгдөж гишүүнээр элсэнэ.

Зургаадугаар зүйл. МҮОХ-ны гишүүн

6.1. МҮОХ-ны гишүүд нь дараах хүмүүсээс бүрдэнэ.

1. Энэ дүрмийн 5.1-р зүйлд дурдсан гишүүн байгууллага тус бүрээс нэг хүн
2. Монгол улсын иргэн ОУОХ-ны гишүүн, хүндэт гишүүн
3. Сүүлийн 3 удаагийн олимпийн наадамд оролцсон тамирчдын төлөөлөгч 2 хүн
4. Олимпийн наадмын медальт тамирчдын төлөөлөгч 2 хүн

6.2 Гишүүдийн санал хураалтын бүрэлдэхүүн

Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын олон улсын холбооны гишүүн үндэсний холбоод нь МҮОХ-ны /тухайлбал, Олимпийн чуулган ба Гишүүдийн хурал/ нийт санал хураалтын бүрэлдэхүүний олонхийг бүрдүүлэх ёстой. Мөн түүнчлэн Олимпийн наадамтай холбоотой асуудлыг Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд болон Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын олон улсын холбооны гишүүн үндэсний спортын холбоодын саналаар шийдвэрлэнэ.

6.3. МҮОХ-ны гишүүн нь тухайн гишүүн байгууллагын сонгуульт ажил, үүргээс огцрох эсвэл татгалзах тохиолдолд гишүүнээс шууд чөлөөлөгдсөнд тооцогдоно. Түүнийг чөлөөлөгдснөөс хойш 30 хоногийн дотор орны гишүүнээр сонгуулах хүний нэрийг МҮОХ-нд ирүүлнэ. Гишүүний асуудлыг Гүйцэтгэх зөвлөл хэлэлцэн, гишүүдийн хурлаар оруулж баталгаажуулна.

6.4. Спортын захиргааны байгууллагад ажиллаж буй хүмүүсээс бусад МҮОХ-ны гишүүд нь үүргийнхээ дагуу гүйцэтгэсэн ажлынхаа төлөө ямар нэгэн цалин хөлс авахгүй.

6.5 Засгийн газар болон Удирдах байгууллагаас ҮОХ-ны гишүүнийг томилж болохгүй.

6.6 МҮОХ-ны гишүүд нь аль нэгэн байнгын комисс эсвэл ажлын хэсгийн гишүүний үүргийг гүйцэтгэж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МҮОХ-НЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Долоодугаар зүйл. МҮОХ-ны удирдлагын тогтолцоо

7.1. МҮОХ-ны удирдлагын тогтолцоо нь чуулган, гишүүдийн хурал, гүйцэтгэх зөвлөл, Ерөнхийлөгчөөс бүрдэнэ.

Наймдугаар зүйл. Монголын олимпийн чуулган

8.1. Монгол улсад олимпийн хөдөлгөөнийг удирдах дээд байгууллага нь Монголын Олимпийн Чуулган мөн. Чуулган нь 4 жил тутамд Зуны Олимпийн наадмын дараа хуралдана.

8.2. Олимпийн чуулганыг хуралдуулах хугацааг 3 сараас доошгүй хугацааны өмнө МҮОХ-ны гишүүдийн хурлаас зарлана. Хэлэлцэх асуудлыг 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэх ба Чуулган эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлсэн гишүүдийн саналыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.

8.3. Олимпийн чуулганд 6.1-д заасан МҮОХ-ны гишүүд, дүрмийн 5.1-ийн 1-д заасан гишүүн холбоодын нэг төлөөлөгч оролцоно.

8.4. Чуулганд нийт гишүүдийн 75-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно. **Бүх шийдвэрийг санал хураалтад оролцогсдын олонхийн саналаар гаргана.**

8.5. Чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. МҮОХ-ны үйл ажиллагааны тайлан
2. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
3. ҮОХ-ны ерөнхийлөгч болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд, дэд ерөнхийлөгчдийг сонгох
4. МҮОХ-ны гишүүдийг батламжлах
5. **Дүрмийн 13-р зүйлд заасны дагуу Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг сонгох**

8.6. Чуулган эхлэхээс нэг сарын өмнө МҮОХ-ны гишүүн байгууллагаас Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ.

8.7. Ерөнхийлөгч болон гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн сонгуулийг нууц санал хураалтаар явуулна. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нийт саналын 50-иас дээш хувийг авсан тохиолдолд сонгогдсонд тооцогдоно. Хэрэв аль ч нэр дэвшигч 50-иас дээш хувийн санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг үлдээж дахин санал хурааж шийдвэрлэнэ.

8.8. Гишүүдийн 75-аас доошгүй хувь нь **гарын үсэг зурж бичгээр** санал гаргасан тохиолдолд ээлжит бус чуулганыг хуралдуулна.

Есдүгээр зүйл. Гишүүдийн хурал

9.1. Гишүүдийн хурал нь жилд нэгээс доошгүй удаа хуралдана.

9.2. **Гишүүдийн хуралд** нийт гишүүдийн 50-иас дээш хувь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. **Гишүүдийн хурлын бүх шийдвэрийг санал хураалтад оролцогсдын олонхийн саналаар гаргана.**

9.3. Гишүүдийн хурлаар дараахь асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Үйл ажиллагааны тайлан
2. Аудитын шалгалт хийлгэсэн санхүүгийн тайлан
3. Шинэ гишүүн ба байгууллагыг батламжлах
4. Дүрмийн 6.3 ба 10.10 заалтын дагуу Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг нөхөн сонгох /шаардлагатай тохиолдолд\
5. **МҮОХ-ны Дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах**

6. МҮОХ-ны Чуулган хуралдуулах товыг зарлах /зөвхөн Чуулганы өмнөх гишүүдийн хурлаар/

7. Бусад асуудал

9.4. Шаардлагатай тохиолдолд саналын эрхтэй гишүүдийн 2/3-оос доошгүй хувийн гарын үсэг зурж, бичгээр гаргасан саналаар ээлжит бус гишүүдийн хурлыг хуралдуулна.

Аравдугаар зүйл. Гүйцэтгэх зөвлөл

10.1. Гүйцэтгэх зөвлөл нь гишүүдийн хурлын хоорондох МҮОХ-ны үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

10.2. Чуулганаар сонгогдох гүйцэтгэх зөвлөл нь дараах 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. Ерөнхийлөгч
2. Дэд ерөнхийлөгч 4 хүн
3. Гүйцэтгэх зөвлөлийн 6 хүн. Үүнд: Хэрэв Монгол улсын иргэн **ОУОХ-ны гишүүн, Хүндэт гишүүн байвал Хартийн дагуу Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байна**

10.3. МҮОХ-ны гишүүн байгууллагаас гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ. Саналыг чуулганаас нэг сарын өмнө МҮОХ-д ирүүлнэ.

10.4. Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд **Чуулганаас** 4 жилийн хугацаагаар сонгогдох ба нийт саналын олонхийг авсан нэр дэвшигч **сонгогдоно**.

10.5. Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүдийг болон тэднийг сонгох саналын олонхийг Олимпийн наадмын хөтөлбөрт ордог спортын олон улсын холбооны гишүүн үндэсний холбоодын төлөөлөгчид бүрдүүлэх ёстой.

10.6. Ерөнхийлөгч нь тэргүүн дэд болон дэд ерөнхийлөгчөөр сонгуулах хүний нэрийг гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийн дотроос дэвшүүлж, Чуулганд санал оруулж, олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.

10.7. Гүйцэтгэх зөвлөлийн хуралд гишүүдийн 50-иас дээш хувь оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцно. Шийдвэрийг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар гаргана.

10.8. Гүйцэтгэх зөвлөл МҮОХ-ны байнгын ажлын албаны орон тоо, бүтцийг төсвийн дагуу батална.

10.9. Гишүүдээс бүрдсэн байнгын комисс, ажлын хэсэг байгуулан чиг үүргийг батална.

10.10 Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн дүрмийн 6.3-н дагуу МҮОХ-ны болон Гүйцэтгэх зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдвөл орны хүнийг гүйцэтгэх зөвлөлийн гишүүнд гишүүдийн хурлаар Дүрмийн 10.3 дагуу нөхөн сонгоно. МҮОХ-ны гишүүнчлэлийн хувьд төлөөлөх холбоо нь дүрмийн 6.3-н дагуу орны хүний нэрийг дэвшүүлж батлуулна.

Арваннэгдүгээр зүйл. Ерөнхийлөгч

11.1. МҮОХ-ны Ерөнхийлөгчийг Олимпын чуулганы төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж нууцаар санал хурааж Олимпын чуулганаас 4 жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхийлөгч орон тооны байна.

11.2. МҮОХ-ны Ерөнхийлөгч дараах эрхтэй.

1. Ерөнхий нарийн бичгийн даргаар томилох хүний талаарх саналыг гүйцэтгэх зөвлөлийн хуралд оруулж, батлуулах
2. Бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах
3. Чуулган, гишүүдийн хурал, гүйцэтгэх зөвлөлийн үйл ажиллагаа, түүний хуралдааныг удирдах
4. МҮОХ-г гадаад, дотоодод төлөөлөх

11.3. МҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн батламжаар Ерөнхийлөгч нь өөрийн эрх мэдлийг бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн байдлаар бусдад шилжүүлж болно.

11.4 Хэрэв ерөнхийлөгч албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд (огцорсон, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эрүүл мэндийн байдлаас цаашид ажиллах боломжгүй болсон, нас нөгчсөн) тэргүүн дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Арванхоёрдугаар зүйл. Ерөнхий нарийн бичгийн дарга

12.1 Ерөнхийлөгчийн саналын дагуу Ерөнхий нарийн бичгийн даргыг гүйцэтгэх зөвлөлийн хурлаас томилох эсвэл чөлөөлнө.

12.2. Ерөнхий нарийн бичгийн дарга нь МҮОХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах орон тооны ажилтан байна.

12.3. Олимпын чуулган, гишүүдийн хурал, гүйцэтгэх зөвлөлийн хурлын шийдвэрийг хангуулах, бэлтгэл ажил, бичиг баримт, ажлын тайлан бэлтгэх, комиссуудын үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Гүйцэтгэх зөвлөлийн хуралд таслах эрхгүйгээр оролцоно.

12.4. ОУОХ-ны эв нэгдлийн сангаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг зохицуулан хэрэгжүүлнэ.

Арвангуравдугаар зүйл. Хянан шалгах зөвлөл

13.1. Хянан шалгах зөвлөлийг (цаашид ХШЗ гэж товчилно) 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр МҮОХ-ны чуулганы төлөөлөгчдөөс нэр дэвшүүлж чуулганаас дөрвөн жилийн бүрэн эрхийн хугацаатай сонгоно.

13.2. ХШЗ нь бүрэлдэхүүнээсээ даргаа сонгоно.

13.3. ХШЗ дараахь үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Үүнд:

1. МҮОХ-ны дүрмийн биелэлт
2. Ерөнхийлөгчийн болон гүйцэтгэх зөвлөлийн шийдвэр нь МҮОХ-ны дүрэм, хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх
3. МҮОХ-ны ажлын алба, харьяа байгууллага, архив, бичиг хэрэг, санхүү
4. Спортын холбоодын үйл ажиллагаа

13.4. ХШЗ нь шалгалтын дүнг гүйцэтгэх зөвлөл, гишүүдийн хуралд танилцуулна.

Арвандөрөвдүгээр зүйл. Төр засгийн байгууллагатай харилцах

14.1 МҮОХ нь биеийн тамир, спортыг хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж, төр, засгийн байгууллагад өргөн барих, яам, газруудтай хамтран ажиллах

14.2 Монгол улсын хуулийн дагуу Олимпын хөдөлгөөн, түүний үйл ажиллагаанд холбогдох асуудлаар Монголын төр, засгийн газартай харилцах, биеийн тамир, спортын талаар гаргасан шийдвэр, даалгаварыг Олимпын Харти, МҮОХ-ны дүрмийн хүрээнд хүндэтгэн биелүүлэх

14.3 Монгол улсын Засгийн газраас Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр эрхлэн гүйцэтгэх, шаардагдах хөрөнгийг улсаас авч зарцуулах, тухайн эх үүсвэрийн ашиглалтыг **Засгийн газарт эргэж тайлагнана**

14.4 Спортын эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хөгжүүлж, үр дүнг сургалт дасгалжуулалтад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

14.5 Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын байгууллагад мэргэжлийн заавар, зөвлөгөө өгөх

Арвантавдугаар зүйл. Гишүүн спортын холбоо

15.1. Гишүүн холбоо нь МҮОХ-ны Дүрмийг хүлээн зөвшөөрч, өөрийн дүрэм болон гишүүнээр нь элссэн **Олон улсын холбооны дүрэм, журмын хүрээнд** үйл ажиллагаагаа явуулах Төрийн бус байгууллага мөн.

15.2. МҮОХ нь Олимпийн Хартийн дагуу нэг төрлийн спортын нэг холбоог хүлээн зөвшөөрнө.

15.3. **МҮОХ-оор хүлээн зөвшөөрүүлж гишүүн нь болохыг хүссэн үндэсний холбоо нь тухайн спортынхоо чиглэлээр бодит үйл ажиллагааг тасралтгүй явуулахын зэрэгцээ, ОУОХ-гоор хүлээн зөвшөөрсөн олон улсын холбооны гишүүн нь байж, түүний дүрэм болон Олимпийн Хартийг бүрэн биелүүлж ажиллах ёстой.**

15.4. Спортын холбоо нь төв, орон нутагт өөрийн салбартай байж, спорт клуб, секцийг мэргэжлийн удирдлагаар хангаж туслалцаа үзүүлнэ.

15.5. Спортын холбоо, клуб нь ивээн тэтгэгч байгууллагын дэмжлэг авч болно.

15.6. Гүйцэтгэх зөвлөл нь спортын холбоодын үйл ажиллагааг уялдуулах зорилгоор спортын холбоодын зөвлөлийг байгуулан хамтран ажиллана.

Арванзургадугаар зүйл. Орон нутгийн салбар зөвлөл

16.1. МҮОХ нь Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгжийн зохион байгуулалтын дагуу өөрийн салбар зөвлөлийг ажиллуулна.

16.2. Салбар зөвлөл нь тухайн орон нутаг дахь МҮОХ-ны бодлогыг хэрэгжүүлэх байгууллага юм.

16.3. Аймаг, дүүргийн салбар зөвлөл тус бүр нэг төлөөлөгчийг сонгон МҮОХ-ны гишүүдийн бүрэлдэхүүнд оруулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **ХӨРӨНГӨ САНХҮҮ, ОНЦЛОХ ЗҮЙЛ**

Арвандолоодугаар зүйл. Хөрөнгө, санхүү

17.1. МҮОХ-ны хөрөнгө санхүү дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

1. ОУОХороо, гадаад, дотоодын байгууллага хүмүүсээс МҮОХ-нд хандивласан техник тоног төхөөрөмж, хэрэглэл материал, эд агуурс, үндэсний болон гадаад валют
2. Спортын үйл ажиллагаанд зориулж байгууллага, иргэдээс МҮОХ-нд эзэмшүүлсэн барилга байгууламж, хөрөнгө оруулалт

3. Спортын маркетинг, мөнгөн хонжворт сугалаа, дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого,
4. Үйл ажиллагааны явцад бүрдсэн архивын материал, олон улсын спортын байгууллагын баримт бичиг
5. МҮОХ-ны гишүүн болон хүлээн зөвшөөрсөн байгууллагын элсэлтийн ба жилийн татвар
6. Бусад орлого

17.2. МҮОХ-ны хөрөнгө санхүүг олимпийн үзэл санаа, спортыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зориулна.

17.3. МҮОХ нь өөрийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

17.4. МҮОХ нь дэргэдээ спорт сугалааны оператор ба олимпийн барааны дэлгүүр зэрэг байгууллагыг Төрийн бус байгууллагын хуульд нийцүүлэн ажиллуулж болно.

Арваннаймдугаар зүйл. Онцлох зүйл

18.1. МҮОХ-ны бэлгэдэл нь олимпийн таван өнгийн цагаригийн дээд талд гал, нар, сарыг дүрслэн дээдэлсэн байх бөгөөд **дор нь “Монголын үндэсний олимпийн хороо” гэсэн бичээстэй байна.**

18.2. МҮОХ-ны туг нь бэлгэдлийг гурван талдаа шар цацагтай 1:2 хэмжээний цагаан давуун дээр байрлуулж “Монголын Үндэсний Олимпийн Хороо” гэсэн бичээстэй байна.

18.3. **МҮОХ өөрийн үйл ажиллагаанд тухайлбал олимпийн наадамд хэрэглэхээр сонгосон туг, бэлгэдлийг ОУОХ-оор зөвшөөрүүлнэ.** МҮОХ-ны бэлгэдлийг хэрэглэх журмыг **Олимпийн Хартийг баримталж** Гүйцэтгэх зөвлөлийн хурлаар тогтоон хэрэгжүүлнэ.

18.4. МҮОХ нь албан бичгийн хуудас, тэмдэг хэрэглэнэ.

18.5. МҮОХ нь өөрийн хэвлэл, шагналтай байна.

Арванесдүгээр зүйл. Маргаан шийдвэрлэх

19.1. Маргаантай асуудлыг МҮОХ-ны дүрэм, Олимпийн харти, Азийн Олимпийн зөвлөлийн дүрэм, Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

19.2. МҮОХ-ны дүрэм нь Олимпийн Хартид ямагт нийцэж түүний утга санааг тод тусгасан байх ёстой. МҮОХ-ны Дүрмийн утга санаа, мөн тайлбарын тухайд эргэлзэх зүйл байвал, мөн энэ дүрэм нь Олимпийн Хартиас зөрөх тохиолдолд Олимпийн Хартийг мөрдөнө.

19.3. Спорттой холбогдолтой аливаа маргаантай асуудлыг спортын маргааныг шийдвэрлэх арбитрын комиссоор шийдвэрлүүлнэ. Энэ комиссын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд 21 хоногийн хугацаанд Швейцарийн Лозанн хотод байрлах Спортын арбитрын шүүхэд давж заалдаж болно. **Энэ шүүх спортын шүүхийн Дүрмийн дагуу асуудлыг эцэслэн шийдвэрлэх болно.**

19.4 МҮОХ-ны Дүрмийн өөрчлөлт, нэмэлтийг ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлөөр оруулж батлуулна.

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРОО